САН ФРАНЦИСКО ХОТОД СУУГАА
ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР

1. **https://consul.notary.mn/login хаяг руу орж итгэмжлэл бичнэ.**




2. **Шинээр бүртгэл үүсгэх товчийг дарж бүртгүүлнэ.**

***Зөвхөн Монгол Улсын иргэн тус системд бүртгүүлэх боломжтой.*** **Гадаад Улсын иргэн болон түр оршин суух үнэмлэхтэй иргэд**




**Ерөнхий консулын газарт өөрийн биеэр ирж итгэмжлэл хийнэ.**

САН ФРАНЦИСКО ХОТОД СУУГАА ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР

3. **Бүртгүүлэхдээ өөрийн овог, нэр, регистрийн дугаарыг иргэний үнэмлэхээсээ харж кирилл үсгээр бичнэ. Регистрийн дугаарын эхний хоёр үсгийг А үсгэн дээр дарж сонгоно.**




4. **Бүртгүүлсэн и-мэйл хаягт нэвтрэх нэр, нууц үг ирэх болно.** **Хэрэв и-мэйл ирэхгүй тохиолдолд ЕКГ-ын ФБ хуудас эсхүл sanfrancisco.mng@gmail.com емайлээр холбогдож нэвтрэх нэр, нууц үгийг хүлээн авах боломжтой.**

**From:** Notariat <office@notary.mn>
**Date:** September 14, 2022 at 10:34:01 PDT
**Subject: Цахим нотариатын системийн хэрэглэгчийн бүртгэл**

Сайн байна уу?

Та доорх мэдээллийг ашиглан системд нэвтрэн орно уу.

Хэрэглэгчийн нэр : sanfrancisco4@mfa.gov.mn
Нууц үг : 8zpJdZ8X

Баярлалаа

САН ФРАНЦИСКО ХОТОД СУУГАА ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР

5. www.consul.notary.mn хаяг руу нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан орж, илгээх итгэмжлэлийн маягтыг сонгоно.




6. Итгэмжлэлийг 5 үйлдэл дамжин бичнэ.




7. **ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ** хэсэгт Баталгаажуулах Дипломат төлөөлөгчийн газар гэсэн хэсэгт САН ФРАНЦИСКО хот дахь Ерөнхий консулын газрыг сонгоно. Хэрэв өөр хотод байрлах ЭСЯ, КГ-ыг сонгосон тохиолдолд тус ЕКГ-ын ажилтанд таны итгэмжлэл харагдахгүй болохыг анхаарна уу.



8. **ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ хэсэгт өөрийн мэдээлэл болон төлөөлөх хүний мэдээллийг нөхөж бичнэ.**



Төлөөлүүлэгч

+ Шинэ төлөөлүүлэгч нэмэх

Гадаадад байгаа Монгол Улсын иргэн

Улс : * АНУ

Хот : * Los Angeles

Гадаадад оршин суугаа хаяг : * 100 River drive, apt 001

Регистрийн дугаар : * ХА54550055

Тайлбар: "Кирилл үсгээр бичнэ үү." Жишээ: АА 12345678

Овог : * Боржигин

Эцэг (эх)-н нэр : * Мягмаржав

Нэр : * Болд

Утасны дугаар : * 4156224000

Төлөөлөгч

+ Шинэ төлөөлөгч нэмэх

– Насанд хүрсэн Монгол Улсын иргэн

Хот/Аймаг : * Улаанбаатар

Сум/Дүүрэг: * Баянзүрх

Баг/Хороо : * 35-р хороо

Оршин суугаа хаяг : * 40г байр 1000 тоот

Регистрийн дугаар : * ХА44505050

Тайлбар: "Кирилл үсгээр бичнэ үү." Жишээ: АА 12345678

Овог : * Боржигин

Эцэг (эх)-н нэр : * Мягмаржав

Өөрийн нэр : * Сүхболд

Утасны дугаар : * 99009900

9. **Баруун доод буланд байрлах дараах товчийг дарж цааш үргэлжлүүлнэ.**



**10. ИТГЭМЖЛЭЛЭЭР ОЛГОХ ЭРХ хэсэгт өөрийгөө төлөөлүүлэн хийх үйлдлүүдийг л сонгоно.**




**11. Хэрэв Таны олгох гэж буй эрх дараах сонголтуудад байхгүй тохиолдолд АГУУЛГА хэсэгт өөрийн олгож буй эрхийг шивж оруулна.**



12. **БУСАД НӨХЦӨЛ хэсэгт итгэмжлэлийн хугацааг бичнэ. Зөвхөн олгох хугацааны ТОО-г бичсэний дараа хоног,сар,жил-ээс аль нэгийг сонгоно. Итгэмжлэлийн хүчинтэй байх хугацаа олгосон өдрөөс 3 жил хүртэл байна.**




13. **ХАВСРАЛТ хэсэгт Төлөөлүүлэгчийн хүчин төгөлдөр хугацаатай Монгол Улсын бичиг баримтын хуулбарыг заавал хавсаргана.**

**Ямар төрлийн итгэмжлэл явуулж байгаагаас шалтгаалан нэмэлт хавсралтуудыг оруулна. Жишээлбэл: үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбарыг оруулна. 2 ба түүнээс дээш файл оруулах бол нэмэх тэмдэг дээр дарж хавсралтыг нэмнэ эсхүл файл олноор оруулах товч дээр дарж олон файл сонгоно оруулна.**



14. **ҮЙЛДЭЛ ХАРАХ хэсэгт өөрийн бичсэн итгэмжлэлийг иргэн та өөрөө сайтар уншиж хянана.**




15. **Консулын ажилтан таны итгэмжлэлийн ерөнхий агуулгыг уншиж, хавсаргасан бичиг баримтуудын хуулбар бүрэн эсэхийг хянах тул итгэмжлэлээр таныг төлөөлж хийх үйлдлүүдийг та бүрэн гүйцэт бичсэнээ сайтар шалгана уу.**

16. **Баруун доод буланд байрлах ХАДГАЛАХ товчийг дарна.**



17. Хадгалах товч дарсны дараа "ДТГ-аар хянуулахаар илгээх үү?" гэсэн асуултад ТИЙМ гэж дарснаар итгэмжлэл Ерөнхий консулын газарт хянуулахаар илгээгдэнэ. Хэрэв ҮГҮЙ гэсэн товчийг дарвал хянуулахаар илгээгдэхгүй "Шинэ" гэсэн төлөвт шилжин зөвхөн танд харагдах болохыг анхаарна уу.







18. Хянуулахаар илгээсэн итгэмжлэлээ илгээсэн эсэхийг шалгах бол Миний үйлчилгээ цэсийн ХЯНУУЛАХ ХҮСЭЛТ рүү орж шалгана.

19. **Илгээсэн итгэмжлэл нь ХЯНУУЛАХ төлөвтэй байгаа бол ЕКГ руу хянуулахаар илгээгдсэн байна гэсэн үг юм. Итгэмжлэлийг хянах хугацаа: ажлын 1-2 хоног болно.**




20. **Хэрэв ШИНЭ гэсэн төлөвтэй хадгалагдсан бол зөвхөн иргэн танд харагдах болохыг анхаарна уу.**




21. **Хэрэв илгээсэн итгэмжлэл нь БУЦААСАН гэсэн төлөвтэй байвал буцаасан товч дээр дарж буцаасан тайлбарыг уншина.**



22. **Мөн таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу буцаасан тайлбар давхар илгээгдэх болно.**




23. **Буцаагдсан итгэмжлэлд засвар оруулахын тулд ЗАСАХ товч дээр дарж засварыг оруулна.**






**24. Хэрэв илгээсэн итгэмжлэл нь зөвшөөрөгдсөн тохиолдолд БАТАЛГААЖСАН ХҮСЭЛТ рүү орж харна.**

**25. Мөн таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу итгэмжлэл хянагдсан тухай болон хэрхэн илгээх талаар мэдээлэл давхар илгээгдэх болно.**



26. **Баталгаажсан хүсэлт дотор итгэмжлэл БАТАЛГААЖСАН эсхүл ШИНЭ гэсэн төлөвтэйгөөр гарч ирэх болно.**




27. **Баталгаажсан хүсэлт доторх итгэмжлэлийг ХАРАХ товч дээр дарж хэвлэн авна.**




28. **Харах товч дарах үед таны бичсэн итгэмжлэл хадгалах эсхүл хэвлэн авах командын хамт гарч ирнэ.**



29. **Хэвлэн гаргаж ирсэн итгэмжлэл дээр өөрийн нэрийн ард эхний зураасан дээр ГАРЫН ҮСГЭЭ зурна, хоёр дахь зураасан дээр гарын үсгийн тайлал буюу өөрийн НЭР-ийг бичнэ.**



хүлээн авах, холбогдох бичиг баримтад төлөөлж гарын үсэг зурах, намайг төлөөлж өргөдөл, гомдол гаргах зэрэг , лавлагаа хүсэх, хүлээн авах, гэрээ бүртгүүлэх үйлдэл хийх бүрэн эрхийг төлөөлөгчид олгож байна.
**Итгэмжлэлийн хугацаа:** Олгосон өдрөөс эхлэн 3 /гурав/ сарын хугацаанд хүчинтэй. Төлөөлөх эрхийг бусдад шилжүүлэх эрхгүй.

***ИРГЭНИЙ ХУУЛИАС:***

*62.4 Төлөөлөгч итгэмжлэлээр эрх олгосон үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.*
*63.3 Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.*
*67.3 Төлөөлүүлэгч хэдийд ч итгэмжлэлээ хүчингүй болгох, төлөөлөгч итгэмжлэлээс татгалзах эрхтэй.*
*67.4 Төлөөлөгч нь бүрэн эрх дуусгавар болсныг мэдмэгц итгэмжлэлийг төлөөлүүлэгчид буцаан өгөх үүрэгтэй.*
*67.5 Төлөөлүүлэгч итгэмжлэлийг хүчингүй болгосон тухай төлөөлөгч буюу гуравдагч этгээдэд шууд, эсхүл тэдэнд хүргэх боломжтой албан ёсны мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэнэ.*
*67.6 Итгэмжлэл дуусгавар болсныг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байхдаа төлөөлөгчөөс бусад этгээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.*
*70. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс өөртэйгөө, түүнчлэн гуравдагч этгээдийн нэрээр өөрөө төлөөлүүлэгчтэй хэлцэл хийхийг хориглоно.*

Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2021 оны 195 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хөлсөнд 10 ам доллар хураав.
**Энэхүү итгэмжлэлийг олгож буй Э.Хонгорзул би итгэмжлэлийн агуулга, үр дагаврыг ойлгож, уншиж танилцсан бөгөөд миний хүсэл зоригт бүрэн нийцсэн тул гарын үсэг зурав.**

| | | | |
|---|---|---|---|
| О.ХОХО | **гарын үсэг** | **нэр** | 2408174212 |
| О.ХОХО | ______________ | ______________ | 24012546 |

30. **Шуудангаар илгээгдсэн итгэмжлэл архивлагдсаныг Баталгаажсан хүсэлт рүү орж шалгана.**



31. **Архивласан итгэмжлэлийг ХАРАХ товч дээр дарж хавсралтуудыг харах боломжтой. Хүлээн авч буй төлөөлөгчид зөвхөн QR code-ний хажууд гарч буй кодыг илгээнэ. Хавсралтаар оруулсан тамга тэмдэгтэй итгэмжлэлийг илгээхгүй болохыг анхаарна уу.**

**Тухайн төлөөлөгч Монгол Улсад байгаа дурын нотариатад QR code-ний хажууд гарч буй кодыг өгч, тамгатай итгэмжлэлийг хүлээн авснаар хүчин төгөлдөр болно.**

